

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	10
2.12. Шилэн дансны мэдээлэл	10
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	11
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3. Менежментийн захидал	12
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан	14
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
САХБАМО	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татварын тайлан



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
П.ГАНХҮҮ ТАНАА

2020.03.13 № 06/868
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайланд аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага


Эрдэнэс Монгол ХХК нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2. Аудитын тайлан

2.1. Оршил

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг гүйцэтгэх захирал П.Ганхүү Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн “Эрдэнэс Монгол” ХХК-ийн эзэмшиж буй “Эрдэнэс Таван Толгой” ХК-ийн 65.2 хувийн хувьцааг эзэмших хуулийн этгээдийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоол болон холбогдох хууль журам, стандартад нийцүүлэн шийдвэрлүүлэх, Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгон гаргасан санхүүгийн тайланд аудит хийлээ.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Эрдэнэс Монгол ХХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарт түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 12 дугаар сарын 16-наас 2020 оны 3 дугаар сарын 11-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 3 дугаар сарын 13-ны өдөр эцэслэн баталгаажуулж, байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, УАГ-ын захиалгаар “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-ийн ахлах аудитор Д.Сайнжаргал, аудитор М.Лхагвасүрэн, аудиторын туслах П.Ганчимэг нар хариуцаж хэрэгжүүлэв.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайланг “Эйч Эл Би Монголиа Аудит” ХХК-д 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 16/176 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Эрдэнэс Монгол ХХК-ийн дүрэмд үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Монгол Улсын байгалийг нөөцийг үр ашигтай ашиглаж уул уурхай, дэд бүтэц, эрчим хүчний салбарт урт хугацааны хөрөнгө оруулалт хийх, бизнесийн үнэ цэнийг нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигч иргэдэд бодит үр ашгийг хүртээх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах үндэсний хөрөнгө оруулалтын компани болно” гэж тодорхойлсон.

Эрдэнэс Монгол ХХК нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн төлөөллийг хэрэгжүүлэх талаар:
 - САХБАМО-ын төрийн эзэмшлийн хувьцаа эзэмших эрх эдлэх;
 - Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашиг, хувьцаа борлуулсны орлого;
 - САХБАМО-ын ашиглах урьдчилгааны орлогыг төвлөрүүлэх;
 - Төрийн эзэмшлийн хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг нэмэгдүүлэх;
- Стратегийн ордын ашиглалтын талаар:
 - Ашигт малтмалын геологийн судалгааны хайгуулын ажил гүйцэтгэх;
 - САХБАМО-ын нөөц, хил хязгаарыг тогтоох аргачлал, зарчмыг боловсруулан эрх бүхий байгууллагаар батлуулах;
 - Ордыг дангаараа болон бусад этгээдтэй хамтран ашиглах;
 - Ашигт малтмалыг олборлох, боловсруулах үйлдвэр байгуулах;
 - Дэд бүтцийн төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх;
 - Нөөцийн хуваарилалт, тээвэр, агуулах, гаалийн хяналтын бүсийн үйлчилгээ;
 - Ашигт малтмалыг боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх;
- Тусгай зөвшөөрөл, эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар:
 - САХБАМО-ын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмших, шилжүүлэх, барьцаалах;
 - САХБАМО-ын тусгай зөвшөөрөл шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тооллогыг зохион байгуулах;
 - Эд хөрөнгө, тоног төхөөрөмж болон оюуны өмчийн эрхийг эзэмших, ашиглах, түрээслэх, худалдах;
- Санхүүжилт эх үүсвэр олох, хуваарилах талаар:
 - САХБАМО-ын ашиглалтын чиглэлээр IPO, PP хийх замаар хөрөнгө оруулалтыг татах;
 - Эрх бүхий байгууллагын шийдвэрээр өрийн бичиг /бонд/ гаргах, хувьцааг нь эзэмшдэг хуулийн этгээдэд зээл олгох;
 - Ашигт малтмалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа төрийн өмчийн оролцоотой компаниудын төрийн эзэмшлийн хувьцааг худалдах, стратегийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах;
- Зөвлөх үйлчилгээ үзүүлэх талаар:
 - Маркетингийн бодлого, дунд, урт хугацааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтийг хангах;
 - ТЭЗҮ, нөөцийн үнэлгээ, хөрөнгө, санхүүгийн төлөвлөлт хийх;
 - САХБАМО-ын мэдээллийг дотоод, гадаадад сурталчлах, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Эрдэнэс Монгол ХХК-ийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрдэнэс Монгол ХХК нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа “Ноён” санхүүгийн программ хангамж ашигладаг байна.

Эрдэнэс Монгол ХХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд нийт зардлын дүн 51,579.3 сая төгрөгөөс тооцон 515.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг өөрчлөөгүй.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23,020.4 сая төгрөгөөр буюу 0.24 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,758.5	5,111.1	(8,647.3)
Авлага	35,115.5	21,765.3	(13,350.2)
Урьдчилж төлсөн зардал/тооцооны	1,830.3	2,615.0	784.6
Бараа материал	26.9	44.9	18.0
Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,128,796.5	9,128,898.1	101.6
Үндсэн хөрөнгө	174,288.5	190,406.6	16,118.1
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	301.4	761.6	460.2
Хойшлогдсон татварын хөрөнгө	7.1	151.0	143.9
Бусад эргэлтийн бус хөрөнгө	41,138.0	68,529.5	27,391.5
Нийт хөрөнгө	9,395,262.8	9,418,283.2	23,020.4
Богино хугацаат өр төлбөр	107,379.2	24,942.9	(82,436.3)
Урт хугацаат өр төлбөр	166,624.5	241,220.1	74,595.7
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	9,121,259.1	9,152,120.1	30,861.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	9,395,262.8	9,418,283.2	23,020.4

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилж төлсөн зардал, урт хугацаат хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө, хайгуул үнэлгээний хөрөнгө, бусад эргэлтийн бус хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 8,647.3 сая төгрөгөөр буурсан нь Монгол улсын хөгжлийн банкинд зээлийн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөрт 23,099.9 сая төгрөг төлсөн нь нөлөөлжээ.

Авлага дансны үлдэгдэл 13,350.1 сая төгрөгөөр буурсан нь БНХАУ-аас өдөрт нэвтрэх нүүрс тээврийн машины тоонд хязгаарлалт тавьснаас шалтгаалан 10,11,12 дугаар саруудад жижиг тээвэрлэгчдийн /оны эхэнд 167 тээвэрлэгчийн 6,740.6 сая төгрөгийн авлагатай байсан бол оны эцсээр 189 тээвэрлэгчийн 4,880.2 сая төгрөг болсон/ эрчим багассантай холбоотой байна. Мөн охин компаниудаас авах авлага болон хүүгийн авлагын нэг жилээс дээших дүнг бусад эргэлтийн бус хөрөнгөд шилжүүлсэн нь нөлөөлжээ.

Авлагын дансны үлдэгдэл 21,765.3 сая төгрөг байна. Үүнд: Татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 134.5 сая, охин компаниудаас /Мон-Атом ХХК, Багануур ХК, Шивээ Овоо ХК, Эрдэнэс Метан ХХК, Эрдэнэс Оюу толгой ХХК, Эрдэнэс Алт Ресурс ХХК, Эрдэнэс Силвер Ресурс ХХК, Эрдэнэс Ассет Менежмент ХХК, Газрын ховор элементийн судалгаа/ авах зээл, зээлийн хүүгийн авлага нийт 15,397.8 сая, ажилчдаас авах авлага 9.0 сая, богино хугацаат авлага 1,022.2 сая, НӨАТ-ийн авлага 323.2 сая, замын хураамжийн авлага 4,876.8 сая, найдваргүй авлага 1.6 сая төгрөг тус тус байна.

Урьдчилж төлсөн зардал/тооцооны данс 784.6 сая төгрөгөөр буурсан нь гэрээний дагуу Монгол Газрын тосны боловсруулах үйлдвэр ХХК-д 380.9 сая төгрөг, Эрчим хүчний экспортын Шивээ энерги цогцолбор төсөлд 239.9 сая төгрөг тус тус шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 16,118.1 сая төгрөгөөр өссөн нь Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын эрхийг Итгэлт бээс ХХК-аар дахин үнэлгээ хийлгүүлэн 158,202.0 сая төгрөгөөр үнэлүүлэн үнэлгээний тайлан болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 10 дугаар тогтоолыг үндэслэн 1,432.2 сая төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан байна. Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын засварын ажлыг 14,625.7 сая төгрөгөөр капиталжуулсан зэрэг нь үндсэн хөрөнгө өсөхөд нөлөөлсөн байна.

Хайгуул ба үнэлгээний хөрөнгө дансны үлдэгдэл 460.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд Багануур ХК болон Асгатын мөнгөний ордын хайгуул үнэлгээний лиценз, хайгуулын зардлыг нэмж бүртгэсэнтэй холбоотой байна. Хайгуул ба үнэлгээний хөрөнгөд Баяндун 443.3 сая, Асгат 108.3 сая, Шивээ Овоо 210.0 сая төгрөг нийт 761.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бусад эргэлтийн бус хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оноос 27,391.5 сая төгрөгөөр өссөн нь нэг жилээс дээш хугацаатай охин компаниудад олгосон зээлийн санхүүжилт бусад эргэлтийн бус хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өглөг дансны үлдэгдэл 24,942.9 сая төгрөг байгаа нь Монгол улсын Хөгжлийн банкны тайлант хугацаанд ногдох зээл болон зээлийн хүүгийн өглөг 20,495.2 сая, ажил гүйцэтгэгч 14 компанийн гүйцэтгэлийн баталгааны өглөг 2,357.4 сая, цалингийн өлөг 2.6 сая, ААНОАТ-ын өглөг 69.3 сая, НӨАТ-ын тооцоо 266.6 сая, Баялгийн санд гэрээний дагуу өгөх өглөг 26.7 сая, хайгуулын ажилд 259.5 сая, хяналт шалгалтын үйл ажиллагааны төлбөрт 580.0 сая, бусад өглөг 885.6 сая төгрөг тус тус байна.

Хөгжлийн банкны зээлийн гэрээ шинэчлэгдэж зээлийн хугацаа 2-9 жил болсноор нэг жилд төлөх зээлийн үндсэн төлбөр буурч компанийн богино хугацаат зээлээс урт хугацаат зээл рүү шилжүүлснээр урт хугацаат өр төлбөр 74,595.7 сая төгрөгөөр өсөхөд нөлөөлсөн байна.

Монгол улсын Хөгжлийн банкны зээлийн өглөг 139,997.7 сая төгрөг, Азийн хөгжлийн банкны зээлийн өглөг 24,455.7 сая, Эрдэнэс Таван Толгой ХК-ийн зээлийн өглөг 76,766.7 сая төгрөг тус тус байна.

Эздийн өмчийн дансны үлдэгдэл 30,861.0 сая төгрөгөөр өссөн нь 1,432.2 сая төгрөгийг дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнасан, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн авто замын засварын ажлыг 14,625.7 сая төгрөгөөр капиталжуулсан зэрэг нь нөлөөлсөн байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 58 тоот тогтоолоор 2019 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө батлагдаж, 2019 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн 11, 2019 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 33 дугаар тогтоолоор тус тус тодотгол хийсэн байна.

Хүснэгт 3. Зорилтот түвшний гүйцэтгэл

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/сая төгрөг/	
			Зөрүү	Хувь
Нэг. Нийт орлого	71,804.1	75,756.1	(3,951.9)	105.5
Замын хураамжийн орлого	67,133.1	70,889.1	(3,756.1)	105.6
Менежментийн төлбөр	2,049.6	2,049.6	-	100.0
Шивээ Овоо талбай ашигласны төлбөр	224.4	226.4	(2.0)	100.9
Бусад орлого	3.8	3.3	0.4	88.1
Хүүгийн орлого	2,393.3	2,587.6	(194.3)	108.1
Хоёр. Үйл ажиллагааны зардал	58,702.7	57,399.1	1,303.6	97.8
А. Гашуун сухайтын авто замын зардал	30,549.3	29,711.4	837.9	97.3
Б. Үйл ажиллагааны зардал	25,496.4	24,894.7	601.7	97.6
В. Нэмэлт зардал	2,657.0	2,793.1	(136.0)	105.1
Гурав. Татварын өмнөх ашиг ашиг (алдагдал)	13,695.0	17,650.0	(3,955.0)	128.9
Орлогын албан татвар	2,973.8	4,064.6	(1,090.8)	136.7
Дөрөв. Цэвэр ашиг (алдагдал)	10,721.3	13,585.4	(2,864.1)	126.7

“Эрдэнэс Монгол” ХХК-ийн цэвэр орлогын 93.6 хувийг замын хураамжийн орлого эзэлж байна. Тайлант онд орлого 3,951.9 сая төгрөгөөр давсан нь нүүрс тээврийн хэмжээ өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

Тайлант онд 58,702.7 сая төгрөгийн үйл ажиллагааны зардлын төсөв батлагдсан байна. Гашуун Сухайтын авто замын зардал 29,711.4 сая, үйл ажиллагааны зардал 24,894.7 сая, “Үйл ажиллагаа, менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хөрөнгө оруулалтын зардал болон бусад зардал 2,793.1 сая нийт 57,399.1 сая төгрөг буюу төлөвлөснөөс 1,303.6 сая төгрөгийг дутуу зарцуулсан байна. Тайлант онд 17,650.0 сая төгрөгийн ашигтай ажиллажээ.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 14 эрсдэл тодорхойлж, нийт 30 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,546.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,439.5 сая төгрөгийн алдааг залруулж, 47.4 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 60.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө. Үүнээс:

1. Автомашины шатахуун зарцуулалтын норм хэтрүүлэн 10.7 сая төгрөг илүү зарцуулсан нь Дэд бүтцийн сайдын 2004 оны "Жишиг норм батлах тухай" 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг"-т заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон

2. Томиллоор явсан, ирсэн зам хоногийг хоёр өдрөөр тооцсон, зам хоног болон байрны зардлыг баталсан хэмжээнээс 28.0 сая төгрөгөөр илүү олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 6-р тогтоол 2.4-д “Албан томиллоор

явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно”, Сангийн сайдын “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 2011 оны 188 дугаар тушаал, 2018 оны 301 дүгээр тушаалтай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн хэмжилт, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

3. Ажилтны докторантын сургалтын төлбөр, гишүүнчлэлийн хураамж 4.3 сая төгрөг байгууллагаас төлсөн нь Эрдэнэс монгол ХХК-ийн дүрэм-ийн 3.1-д “Компани ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн, хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

4. Нэмэгдэл цалин хөлсийг ажилласан хоногт ногдох цалингаас олгоогүй үндсэн цалингаас тооцон 4.4 сая төгрөг илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д “Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгох” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв, үнэлгээ батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Зөрчилд төлбөрийн акт тогтоосон.

5. Өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтнуудад 60.0 сая төгрөгийн тэтгэмж олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д “Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн

6. Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авсан нь ТӨБЗГ-ын журам батлах тухай 2019 оны 271 тоот тогтоол "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 1.2-д “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага өгсөн

7. Үндсэн хөрөнгийн шинжтэй 4 нэр төрлийн 4.6 сая төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд тайлагнасан нь НББОУС16-д “Үндсэн хөрөнгө Дараах шалгууруудыг хангасан биет зүйлсийг хэлнэ. . . . б). Нэгээс дээш тайлант хугацаанд ашиглах”, Санхүү, эдийн засгийн сайдын 2017 оны 13 тоот тушаалын хавсралт “Аж ахуйн нэгж, байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны үлгэрчилсэн зааврын 6.1 Үндсэн хөрөнгө гэж нэгээс дээш тайлангийн хугацаанд ашиглагдахаар хүлээгдэж байгаа . . . хөрөнгийг хэлнэ” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг аудитын явцад залруулав

8. Ном 2.7 сая төгрөгөөр худалдан аваад шууд зарлагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл. Нягтлан бодох бүртгэлийн зарчим 5.1.4.үнэн зөв байх, Монгол улсын Сангийн сайдын 2014 оны 249 тоот "Нягтлан бодох бүртгэлийн дансны заавар" -ын 4-Г, тухайн байгууллагад мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 4.3.2 Бараа материал /хангамжийн материал/ худалдан авах үед ДТ-Бараа материал КТ- Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө/дансны өглөг" гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг аудитын явцад залруулав

9. Итгэлт бээс ХХК-аар 1,432.2 сая төгрөгийн хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэсэн боловч санхүүгийн тайланд дахин үнэлгээний нэмэгдлээр тайлагнаагүй нь Сангийн сайдын 2017 оны 13-р тушаалын хавсралт “Дахин үнэлгээний улмаас хөрөнгийн үлдэгдэл өртөг нэмэгдсэн хэмжээг эзэмшигчийн өмчийн хэсэгт Дахин үнэлгээний нэмэгдэл нэртэйгээр харуулна”. НББОУС 16.31... “Аливаа үндсэн хөрөнгийн бүртгэлд анх хүлээн зөвшөөрсний дараа дахин үнэлгээ хийсэн бол түүнийг дахин үнэлсэн дүнгээр тайлагнана. Дахин үнэлэгдсэн дүн нь дахин үнэлгээ хийсэн өдрийн бодит үнэ цэнээс олж эзэмшсэнээс хойших тооцоолсон хуримтлагдсан элэгдэл болон хуримтлагдсан үнэ цэнийн бууралтын гарзыг хассан дүн байна” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн Хэмжилт, Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг аудитын явцад залруулав

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд Азийн хөгжлийн банктай хамтран Эрдэнэс Монгол ХХК-ийн “Үйл ажиллагаа, менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн зарцуулалт нарийвчлан горим, сорил хэрэгжүүлж амжаагүй тул дараах асуудлыг үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй, хууль дүрэмд нийцсэн эсэхэд тусгайлан гүйцэтгэлийн болон эрсдлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гаргуулах нь зүйтэй гэж үзлээ. Тухайлбал:

1. Эрдэнэс Монгол ХХК -ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх “Үйл ажиллагаа, менежментийн чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийн хөрөнгө оруулалтын өртгийг 41.2 сая ам доллар байна гэж тооцоолсон бөгөөд төслийн зардлын 85 хүртэлх хувь буюу 35.0 сая ам долларын санхүүгийн эх үүсвэрийг Азийн Хөгжлийн Банкны энгийн нөхцөлт зээлээр санхүүжүүлэх үлдсэн 15 хувь буюу 6.2 сая ам долларын тоног төхөөрөмж, төсөл хэрэгжүүлэгч нэгжийн тээврийн хэрэгсэл, урсгал зардал бие даасан зөвлөхүүдийн нийгмийн даатгалын шимтгэл зэрэг зардлуудыг Эрдэнэс Монгол ХХК-аас санхүүжүүлэхээр 2016 онд Монгол Улсын Засгийн газраас өрийн баталгаа гаргуулан 15 жилийн хугацаатай зээлийн санхүүжилтээр дараах ажлуудыг хийхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Компанийн стратегийг шинэчлэн боловсруулах
- Үйл ажиллагаа, бүтээмжийг сайжруулах
- Хөрөнгө оруулалтын чадавхийг бэхжүүлэх, төрөлжүүлэх
- Удирдлагын нэгдсэн мэдээллийн систем нэвтрүүлэн ажиллах

2. Дээрх ажлын хүрээнд 2019 онд нийт 2,789.5 сая төгрөгийн зардал гарснаас зөвлөх үйлчилгээний төлбөрт 570.0 сая төгрөг, Засгийн газрын өрийн баталгааны сангаас гаргасан мөнгөн дүнгийн тайлант онд ногдох нь 702.1 сая төгрөг, Азийн хөгжлийн банкны үүрэг хүлээсний шимтгэл, зээлийн хүүгийн зардалд 734.7 сая төгрөг, цалин нийгмийн даатгалын шимтгэлд 736.8 сая төгрөг, түрээсийн төлбөрт 45.8 сая төгрөгийн зардал тус тус гарсан байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Эрдэнэс Монгол ХХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалттай холбоотой 14 мэдээллийг хугацаанд нь байршуулсан, төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг жилийн эцэст хугацаа хоцроож байршуулсан байна. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл бонд, зээл, өрийн бичиг, баталгаа түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа

шийдвэр их хэмжээнд тооцогдохуйц хэлцэлд гаргасан баталгаа, батлан даалтын мэдээллийг байршуулаагүй байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 4 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төлөвлөгөө гүйцэтгэлд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, СТОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг үзүүлэв. Үүнд:

3.1. Урт хугацаат хөрөнгө оруулалтын данстай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Эрдэнэс Тавантолгой ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчээр Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлж Эрдэнэс Тавантолгой ХХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани байсныг хүчингүй болгосон байна. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд 933 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 9,125,403.5 сая төгрөгийн 9,780,711,099 ширхэг хувьцаа Эрдэнэс Монгол ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй хэвээр байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоолын 6 , НББОУС 39-ын 17 дугаар зүйл (а) "Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээнд хамаарах гэрээний эрхийн хүчинтэй хугацаа дууссан, 18 (а) Санхүүгийн хөрөнгийн мөнгөн гүйлгээг хүлээн авах гэрээний эрхийг шилжүүлсэн ба энэ нь үл хүлээн зөвшөөрөхтэй холбоотой 20 дугаар зүйлд нийцсэн бол аж ахуйн нэгж санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө" заалт хэрэгжихгүй байх.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

"Эрдэнэс Монгол" ХХК-ийн эзэмшиж буй "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн 65.2 хувийн хувьцааг эзэмших хуулийн этгээдийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам болон Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай зөвшилцөн Засгийн газрын 2018 оны 245 тоот тогтоол болон холбогдох хууль журам стандартад нийцүүлэн шийдвэрлүүлэх.

3.1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

3.2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Шилэн дансанд байршуулах зарим мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д төрийн чиг үүрэгт хамаарах

ажил, үйлчилгээг хууль тогтоомж, гэрээний үндсэн дээр гүйцэтгэгч, 6 дугаар зүйлийн “6.1.1-д тухайн жилийн төлөвлөгөө жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны дотор мэдээлнэ”, 6.9-д ... Засгийн газар түүний харьяа байгууллагаас гаргасан бонд, үнэт цаас, өрийн бичиг, баталгаа, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний дагуу хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөр, арга хэмжээний дагуу санхүүжиж байгаа энэ хуулийн 3.1-д заасан этгээд нь нийт төсөвт өртөг, хэрэгжилтийн явц, үе шат, зарлага, санхүүжилтийн мэдээллийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу улирал бүр ... шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд байршуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.2 Эрсдэл:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалт хэрэгжүүлж ажилаагүйгүй байх,

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөвлөмжийг мөрдөж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	13,758,484,101.65	5,111,141,782.77
1.1.2	Дансны авлага	6,740,612,757.66	4,878,529,880.30
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	73,101,542.30	134,550,008.75
1.1.4	Бусад авлага	28,301,809,150.92	16,752,265,404.67
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0	0
1.1.6	Бараа материал	26,939,471.20	44,896,462.46
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	1,830,333,077.54	2,614,953,455.24
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)		
	Эргэлтийн хөрөнгийн дүн	50,731,280,101.27	29,536,336,994.19
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	173,840,797,863.15	189,979,449,352.44
1.2.2	Биет бус хөрөнгө	447,684,457.82	427,132,978.06
1.2.3	Биологийн хөрөнгө		
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	9,128,796,451,467.00	9,128,898,051,467.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	301,409,685.04	761,622,745.60
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	7,095,839.48	151,033,026.67
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө		
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	41,138,043,992.11	68,529,530,911.98
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	9,344,531,483,304.60	9,388,746,820,481.75
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	9,395,262,763,405.87	9,418,283,157,475.94
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,476,574,094.92	2,357,429,856.15
2.1.1.2	Цалингийн өглөг	56,642,950.00	2,561,848.41
2.1.1.3	Татварын өр	1,744,958,363.49	325,000,786.06
2.1.1.4	НДШ-ийн өглөг	0.00	0.00
2.1.1.5	Богино хугацаат зээл	85,297,739,852.00	17,520,000,000.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	2,294,205,401.79	2,975,196,209.69
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	1,463,477.02	60,000.00
2.1.1.9	Нөөц /өр төлбөр/		0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	15,507,620,441.80	1,762,636,626.80
2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (Борлуулах бүлэг хөрөнгөд) хамаарах өр төлбөр		
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	107,379,204,581.02	24,942,885,327.11
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	105,181,996,984.93	164,453,451,465.28

2.1.2.2	Нөөц /Өр төлбөр/		
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	61,442,454,485.29	76,766,690,101.73
	Урт хугацаат өр төлбөрийн дүн	166,624,451,470.22	241,220,141,567.01
2.2	Өр төлбөрийн нийт дүн	274,003,656,051.24	266,163,026,894.12
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч-төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.2	Өмч-хувийн		
2.3.3	Өмч-хувьцаат	3,000,000.00	3,000,000.00
2.3.4	Халаасны хувьцаа		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		17,175,601,462.26
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	9,128,184,251,467.00	9,128,284,251,467.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	-7,028,144,112.37	6,557,277,652.56
2.3.11	Эздийн өмчийн дүн	9,121,259,107,354.63	9,152,120,130,581.82
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	9,395,262,763,405.87	9,418,283,157,475.94

4.2. Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	72,673,389,358.58	73,096,593,159.87
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	24,756,602,935.43	19,123,777,592.28
3	Нийт ашиг (алдагдал)	47,916,786,423.15	53,972,815,567.59
4	Түрээсийн орлого		0
5	Хүүгийн орлого	2,346,860,601.24	2,587,603,300.64
6	Ногдол ашгийн орлого		0
7	Эрхийн шимтгэлийн орлого		0
8	Бусад орлого		71,853,541.75
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	8,454,045,662.02	25,858,677,316.02
11	Санхүүгийн зардал	11,631,805,066.98	12,024,382,022.33
12	Бусад зардал		392,270,824.43
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-1,533,400,619.04	-706,936,513.02
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-64,171,877.64	
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)		
17	Бусад ашиг (алдагдал)	-257,498,715.5	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	28,322,725,083.19	17,650,005,734.18
19	Орлогын татварын зардал	6,736,881,858.55	4,064,583,969.04
20	Татварын дараах ашиг (алдагдал)	21,585,843,224.64	13,585,421,765.14
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	21,585,843,224.64	13,585,421,765.14
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Нийт дэлгэрэнгүй орлогын дүн		
25	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	2018 оны 12-р сарын 31	2019 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	68,760,462,564.55	79,856,784,659.44
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	68,704,149,945.55	79,818,529,593.44
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0	0
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	25,918,408.00	2,507,500.00
1.1.4	Буцаан авсан албан татвар		0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		0
1.1.6	Бусад мөнгөн орлого	30,394,211.00	35,747,566.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	84,898,511,023.94	78,430,344,352.57
1.2.1	Ажиллагчдад төлсөн	3,833,255,973.72	3,697,041,988.00
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	752,252,983.59	906,566,354.77
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	164,985,143.55	701,902,505.86
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	-	-
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	116,994,548.32	195,346,696.00
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	10,484,414,837.22	9,906,598,506.98
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	10,447,900,185.18	11,394,283,029.82
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	87481840	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	59,011,225,512.36	51,628,605,271.14
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-16,138,048,459.39	1,426,440,306.87
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,132,914,621.70	441,793,292.91
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	22470350	
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого		
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого		
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	63,418,408.82	58,366,878.57
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	1,047,025,862.88	383,426,414.34
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг		0
2.1.8	Бусад мөнгөн орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	2,921,401,869.21	568,136,289.20
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	2,730,028,530.93	497,030,769.20
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	191,373,338.28	71,105,520.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа		
2.2.6	Бусад мөнгөн зарлага		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,788,487,247.51	-126,342,996.29
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	19,813,034,497.28	3,251,470,935.50
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	19,726,072,341.66	3,172,267,381.34
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас		

	гаргаснаас хүлээн авсан		
3.1.3	Төрөл бүрийн хандив		
3.1.4	Бусад мөнгөн орлого	86,962,155.62	79,203,554.16
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	13,198,910,564.97
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн		13,193,352,673.72
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.2.3	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
3.2.4	Төлсөн ногдол ашиг		
3.2.5	Бусад мөнгөн зарлага		5,557,891.25
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	19,813,034,497.28	-9,947,439,629.47
4	Валютын ханшийн зөрүү		
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	1,886,498,790.38	-8,647,342,318.89
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,871,985,311.00	13,758,484,101.65
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,758,484,101.38	5,111,141,782.77

4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан дүн	Эздийн өмчийн дүн
1	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	206,000,000.00		18,256,368,502,934.00	21,084,432,337.11	18,235,490,070,596.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	206,000,000.00	0.00	18,256,368,502,934.00	21,084,432,337.11	18,235,490,070,596.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00			0.00	0.00
5	Тайлант үеийн үр дүн				14,056,288,224.74	14,056,288,224.74
6	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	103,000,000.00	0.00	9,128,184,251,467.00	-7,028,144,112.37	9,121,259,107,354.63
8	Тайлангийн үеийн цэвэр ашиг				13,585,421,764.93	13,585,421,764.93
9	Бусад дэлгэрэнгүй орлого		17,175,601,462.26			17,175,601,462.26
10	Өмчид гарсан өөрчлөлт			100,000,000.00		100,000,000.00
11	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	103,000,000.00	17,175,601,462.26	9,128,284,251,467.00	6,557,277,652.56	9,152,120,130,581.82

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020/03/11	Аудитын нэр: Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудит	Аудитын код: САГ-2020/10/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллаг аас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Автомашинны шатахуун зарцуулалтын норм хэтрүүлсэн	10.7	Акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
2	Томилолтоор явсан, ирсэн зам хоногийг хоёр өдрөөр тооцсон, зам хоног болон байрны зардлыг баталсан тушаалаас илүү олгосон.	28.0	Акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
3	Ажилтны докторантын сургалтын төлбөр, ажилтны гишүүнчлэлийн хураамжийг байгууллагаас төлсөн.	4.3	Акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
4	Нэмэгдэл цалин хөлсийг ажилласан хоногт ногдох цалингаас олгоогүй үндсэн цалингаас олгосон.	4.4	Акт	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
5	Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авсан		Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
6	Өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтнуудад тэтгэмж олгосон.	60.0	Албан шаардлага	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
7	Эрдэнэс Тавантолгой ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцаа эзэмшигчийн эрх хэрэгжүүлэгчээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт шилжүүлж Эрдэнэс Тавантолгой ХХК нь Эрдэнэс Монгол ХХК-ийн охин компани байсныг хүчингүй болгосон боловч Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвийн бүртгэлд 9,125,403.5 сая төгрөгийн хувьцаа Эрдэнэс Монгол ХХК-ийн эзэмшилд бүртгэлтэй хэвээр байна.		Зөвлөмж өгсөн	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
8	Шилэн дансанд байршуулах зарим мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.		Зөвлөмж	Гүйцэтгэх захирал, Ерөнхий нягтлан бодогч	П.Ганхүү, Д.Отгонцэцэг
	Нийт	107.5			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АКТ

2020 оны 03 дугаар сарын 23

№ 02/69

Улаанбаатар хот

СМН 2020/10/СТА-ТӨЧГ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Автомашины шатахуун зарцуулалтын норм 10,735,199 /арван сая долоон зуун гучин таван мянга нэг зуун ерэн есөн/ төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 болон Дэд бүтцийн сайдын 2004 оны "Жишиг норм батлах тухай" 19 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт "Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг" заалтыг зөрчсөн.
- Ажилтны докторантын сургалтын төлбөр, гишүүнчлэлийн хураамжийн төлбөр 4,263,742 /дөрвөн сая хоёр зуун жаран гурван мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөгийг байгууллагаас төлсөн нь Эрдэнэс монгол ХХК-ийн дүрэм-ийн 3.1-д "Компани ашгийн төлөө үйл ажиллагаа эрхлэн, хувьцаа эзэмшигчийн үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэнэ" гэсэн заалтыг зөрчсөн.
- Томилолтоор явсан, ирсэн зам хоногийг хоёр өдрөөр тооцсон, зам хоног болон байрны зардлыг Сангийн сайдын баталсан тушаалаас 28,034,177 /хорин найман сая гучин дөрвөн мянга нэг зуун далан долоон/ төгрөг илүү олгосон нь Монгол улсын Засгийн газрын 2019 оны "Журам батлах тухай" 6-р тогтоол 2.4-д "Албан томилолтоор явсан, буцаж ирсэн өдрийг нэгтгэн нэг хоногт тооцно", Сангийн сайдын "Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 2011 оны 188 болон 2018 оны 301 дүгээр тушаалын зөрчсөн.
- Нэмэгдэл цалин хөлсийг ажилласан хоногт ногдох цалингаас олгоогүй үндсэн цалингаас тооцон 4,428,400 /дөрвөн сая дөрвөн зуун хорин найман мянга дөрвөн зуун/ төгрөгөөр илүү олгосон нь Хөдөлмөрийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1-д "Ажилтны цалин хөлсийг хийснээр, цагаар, бусад хэлбэрээр хөдөлмөрийн үр дүнд нь тохируулан олгох" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-д "Аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих...", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2016 оны 95 тоот тушаалаар баталсан "Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.3. "Бусдад өгөх төлбөр тооцоог зөрүүтэй тооцоолж олгосон" заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харилцагч албан тушаалтанд харилцаа тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.

\\10.10.10.20\Richie_Kheree\Akt\2020\0320SAG2.Docx

001090181

1. Автомашины шатахуун зарцуулалтын норм 10,735,199 /арван сая долоон зуун гучин таван мянга нэг зуун ерэн есөн/ төгрөг, Ажилтны докторантын сургалтын төлбөр, гишүүнчлэлийн хураамжийн төлбөр 4,263,742 /дөрвөн сая хоёр зуун жаран гурван мянга долоон зуун дөчин хоёр/ төгрөг, Томилолтоор явсан, ирсэн зам хоногийг хоёр өдрөөр тооцсон, зам хоног болон байрны зардлыг Сангийн сайдын баталсан тушаалаас 28,034,177 / хорин найман сая гучин дөрвөн мянга нэг зуун далан долоон/ төгрөг, Нэмэгдэл цалин хөлсийг ажилласан хоногт ногдох цалингаас олгоогүй үндсэн цалингаас тооцон 4,428,400 /дөрвөн сая дөрвөн зуун хорин найман мянга дөрвөн зуун/ төгрөг, Нийт 47,461,518 /дөчин долоон сая дөрвөн зуун жаран нэгэн мянга таван зуун арван найман/ төгрөгийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор буруутай албан тушаалтнаар төлүүлэх, Төв төрийн сан дахь Үндэсний аудитын газрын улсын төсвийн орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Монгол ХХК-ийн захирал П.Ганхүү, ерөнхий нягтлан бодогч Д.Отгонцэцэг нарт даалгав.

АКТЫГ

<p>ӨГСӨН: САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЗУЛ ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК ЗАХИРАЛ  Ч.ЭНХТУЯА</p>	<p>ЗӨВШӨӨРСӨН: ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  П.ГАНХҮҮ ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ Д.ОТГОНЦЭЦЭГ</p>
---	---

ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК
 Mongolia Audit LLC
 УЛААНБААТАР ХОТ
 1118274809 ☎ 52659.2
 АМТ02977

ERDENES MONGOL
 1118279710 ☎ 5124913

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2020 оны 03 дугаар сарын 23

№ 02/152

Улаанбаатар хот

СЭНГ 2020/10/СТА-ТӨЧГ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2-т заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Монгол ХХК-ийн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авсан, Өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтнуудад 60,044,470.00 /жаран сая дөчин дөрвөн мянга дөрвөн зуун далан мянган/ төгрөгийн тэтгэмж олгосон зэрэг зөрчил илэрсэн нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын "журам батлах тухай 2019 оны 271 тоот тогтоол", "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх" журмын 1.2 Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх тухай саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ", Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Ажил олгогч нь энэ хуулийн 37.1.6, 40.1.1, 40.1.2, 40.1.3-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан ажилтанд нэг сар, түүнээс дээш хугацааны дундаж цалин хөлстэй тэнцэх тэтгэмж олгоно" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал, хэмжилт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөрийг барагдуулах акт тавих, зөрчлийг арилгах албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 4.1-д заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шийдвэргүйгээр хөрөнгө худалдан авсан зөрчлийг арилгах, Хөдөлмөрийн тухай хуулийн заалтад заагдаагүй өөрийн хүсэлтээр ажлаас халагдсан ажилтнуудад тэтгэмж олгохгүй байх, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.
2. Дээрх асуудлуудын биелэлтийг 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Эрдэнэс Монгол ХХК-ийн захирал П.Ганхүү, ерөнхий нягтлан бодогч Д.Отгонцэцэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТОР

Б.ЭРДЭНЭЗУЛ
ЭЙЧ ЭЛ БИ МОНГОЛИА АУДИТ ХХК
ЗАХИРАЛ

Ч.ЭНХТУЯА

ЗӨВШӨӨРСӨН:

ЭРДЭНЭС МОНГОЛ ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

П.ГАНХҮҮ

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Д.ОТГОНЦЭЦЭГ

Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.2-д "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу харууцагч албан тушаалтанд харуулага тооцуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.